

БАТЛАВ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-
ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


М.МӨНХӨӨ



БАТЛАВ:

ОЙН ХАЙГУУЛ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ


Б.САРАНГУА



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр

№ 0023/85

Улаанбаатар хот

Нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК /РД:6021646/ цаашид “Захиалагч” гэхийг төлөөлж Захиргаа удирдлагын хэлтсийн дарга Б.Ган-Очир, нөгөө талаас Ойн Хайгуул ХХК /РД: 2543281, улсын бүртгэлийн 9011013087 дугаар/-тай цаашид “Ажил гүйцэтгэгч” гэхийг төлөөлж Төслийн менежер Б.Алтансүх бид /цаашид хамтад нь “Талууд” гэх/ Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийг тус тус үндэслэн, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Эрчим хүчний сайдын 2021 оны А/218 дугаар тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор дараах нөхцөлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1. Нийтлэг заалт

- 1.1. Энэхүү гэрээгээр Ажил гүйцэтгэгч нь Захиалагчийн өгсөн даалгаврын дагуу Дундговь аймгийн нутаг дэвсгэрт Эрчим хүчний салбарын ойн төгөл байгуулахаар заасан, хуваарьт газарт ногоон зурвас байгуулах зорилгоор мод тарих, арчлах, тохижуулах ажлыг гэрээнд заасан хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх, ажлын гүйцэтгэлийн талаар Захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.
- 1.3. Гэрээний хавсралтаар хийгдэх ажил, газрын байршлыг хавсаргав.
- 1.4. Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

2. Гэрээний хугацаа

- 2.1. Ажил эхлэх хугацаа: Гэрээ албажсан өдрөөс
- 2.2. Ажил дуусах хугацаа: 2023.11.01.
- 2.3. Гүйцэтгэсэн ажил 3 жилийн баталгаат хугацаатай байна.

3. Төлбөр тооцоо

- 3.1. Дундговь аймгийн нутаг дэвсгэрийн хуваарьт газарт насос, усалгааны систем, ёмкост, мотор, хашаа, шон, модны суулгац, хар шороо, био ялзмаг, чийг баригч, бордоо нийлүүлж суурилуулах, тээвэр, мод тарих, модны нүх ухах, нөхөн тарилт, арчилгаа, тохижилтын ажлын төлбөрт нийт 18,000,000 /Арван найман сая/ төгрөг болно.

3.2. Төлбөрийг гэрээ байгуулагдсан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн ажил гүйцэтгэгчийн дансанд бүрэн шилжүүлнэ.

4. Захиалагчийн эрх, үүрэг

- 4.1. Тарих модоо сонгох эрхтэй.
- 4.2. Төлбөрөө гэрээнд заасан хугацаанд нь төлөх үүрэгтэй.
- 4.3. Гэрээгээр гүйцэтгэсэн ажлын тайлан, үйл ажиллагааг баримтжуулан зураг зэргийг хугацаанд нь шаардаж авах эрхтэй.
- 4.4. Ажлын гүйцэтгэлд хяналт тавих, явцын талаарх мэдээллийг авах эрхтэй.
- 4.5. Тариалалтыг хугацаандаа дуусгахыг шаардах эрхтэй.
- 4.6. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал ажил хүлээн авснаас хойш 3 жилийн дотор гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.
- 4.7. Захиалагч нь гэрээнд тусгагдсан ажлыг хүлээн авна.

5. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 5.1. Гүйцэтгэгч нь хот суурин газарт ногоон зурвас байгуулах ажлын стандартыг мөрдөн өөрийн мод үржүүлгийн газарт бэлтгэсэн өөрийн модыг үржүүлгийн талбайгаас шууд шилжүүлэн авч суулгах ажлыг календарчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.
- 5.2. Ажлыг 2.1, 2.2-д заасан хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
- 5.3. Гүйцэтгэгч нь харилцан тохиролцсон төлбөрт багтаан гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэнэ.
- 5.4. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.5. Ажлын тайлан, үйл явцыг баримтжуулах зорилгоор ажлын явц, насос, ёмкост, хашаа, бууц, бордоо, усалгааны системийн зургийг хавсаргаж 2023 оны 11 дүгээр сарын 10-ны дотор захиалагчид хүлээлгэн өгнө.
- 5.6. Жил бүр модны ургалтын талаарх тайлан, мэдээг захиалагч талд хүргүүлнэ.
- 5.7. Захиалагч ажлын үр дүнг хугацаандаа авах үүргээ биелүүлээгүй бол ажлын үр дүнг хүлээн авсанд тооцно.
- 5.8. Захиалагчаас төлбөрөө төлөхийг шаардах эрхтэй.
- 5.9. Ногоон зурвас байгуулах ажлыг батлагдсан зураг төслийн дагуу чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, захиалагчид хүлээлгэн өгнө.

6. Талуудын хүлээх хариуцлага

- 6.1. Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд нийт төлбөрийн үнийн дүнгийн 0.1 хувиар тооцож алданги төлнө.
- 6.2. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.3. Торгууль, алданги төлсөн нь материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

7. Давагдашгүй хүчин зүйл

- 7.1. Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл /тухайлбал : газар хөдлөлт, үер, гал түймэр, хар салхи, халдварт өвчний тархалт болон байгалийн бусад аюулт үзэгдэл, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/ -ийн нөхцөл байдал үүссэний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас /алданги, торгууль/ чөлөөлөгдөх үндэслэл болно.

7.2. Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухай нотолгоог Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим гэрчилнэ.

8. Бусад заалт

8.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах бол хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ. Гэрээнд оруулсан аливаа өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй нэг хэсэг болно.

8.2. Талуудын хооронд маргаан гарвал үл маргах журмаар шийдвэрлэх ба тохиролцоонд хүрч чадахгүйд хүрвэл Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын ба Үндэсний Арбитрт түүний Арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийн дагуу Монгол Улсад эцэслэн шийдвэрлүүлнэ.

8.3. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

9. Нэмэлт нөхцөл

10. Талуудын гэрээ байгуулсан төлөөлөл:

Захиалагчийг төлөөлж

Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга




Б.Ган-Очир

СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч



Ө.Удвал

ААХХ-ийн дарга



Г.Баттулга

Хуулийн мэргэжилтэн

Г.Саруул


Хүний нөөцийн мэргэжилтэн



Т.Ичинхорлоо

гүйцэтгэгчийг төлөөлж:

Ойн хайгуул ХХК-ийн төслийн менежер



Б.Алтансүх

11. Хаяг:

Амгалан дулааны станц ТӨХК-ийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот
Баянзүрх дүүрэг, 8-р хороо
УС-15 гудамж, 1-1 тоот .
Компанийн өөрийн байр
Утас:99015032, 99047300.
И-мэйл:amgalan@ahp.energy.mn

Ойн хайгуул ХХК-ийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, 7-р хороо,
Эрхүүгийн гудамж 26-р байр 1 тоот
Утас:99243535, 86351616
И-мэйл:info.oinkhaiguul@mail.com